



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

“НАЛАЙХ ДЦС” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.ӨСӨХБАЯР ТАНАА

2014.04.30 № 04/44 ЧАТ-САТ/2014/46/СТНТ/ТНЦТ

Зөрчлийг арилгуулах тухай

“Налайх ДЦС” ТӨХК-ийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Дулаан үйлдвэрлэх технологийн нүүрс худалдан авах тендер шалгаруулалтад дараах зөрчил илэрлээ.


Нүүрс худалдан авах үнийг батлагдсан төсвөөс хэтрүүлэн нэг тонн нүүрсийг 40.0 мянган төгрөгөөр худалдан авахаар зарласан ба тендерт санал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдээс хамгийн сайн үнэлэгдсэн оролцогчийг шалгаруулаагүй, үнэлгээний хорооны хурлаар бүх оролцогчтой гэрээ байгуулах шийдвэр гаргаж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.5, 8.7.4, 14.1.5, 27, 28, 29 дүгээр зүйлийн заалтуудыг зөрчсөн, 152.8 сая төгрөгийн төсөв хэтрүүлэн худалдан авалт хийсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг гарган 2013 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг “Налайх ДЦС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал М.Өсөхбаяр нягтлан бодогч Б.Доржмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

ШИНЖЭЭЧ



Н.НЯМДАВАА